



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/10-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363047 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4. Материаллаг байдал.....	14
3.5. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	14
3.5.1. Мөнгөн хөрөнгө.....	14
3.5.2. Авлага	14
3.5.3. Бараа материал.....	15
3.5.4. Үндсэн хөрөнгө	16
3.5.5. Өр төлбөр	17
3.5.6. Засгийн газрын хувь оролцоо.....	17
3.5.7. Зарлагын данс.....	18
3.6. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга.....	19
3.6.1 Төсвийн төлөвлөлт	21
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	21
3.6.3 Нэмэлт төсөв.....	22
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	23
3.8. Аудитын гол асуудал	24
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
3.9.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	24
3.9.2. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	24
3.10. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	25
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	25
4. Аудитын илрүүлэлт	25
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв



САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
С.ШИЖИРБААТАР ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № СЭА-2022/10-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч. ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		423,388.5	645,095.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	94,913.6	329,394.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	197,631.2	135,882.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	130,843.7	179,818.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		5,306,937.3	5,208,516.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	5,306,937.3	5,208,516.6
39200	Биет хөрөнгө		5,156,282.7	5,059,164.5
39300	Биет бус хөрөнгө	13	150,654.6	149,352.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		5,730,325.8	5,853,611.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		13,030.3	12,553.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	13,030.3	12,553.4
41300	Өглөг	17а, 17б	13,030.3	12,553.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,717,295.5	5,841,058.4
51	Засгийн газрын хувь оролцоо		5,717,295.5	5,841,058.4
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		2,386,441.9	2,386,441.9
51200	Хуримтлагдсан үр дүн		95,730.6	219,493.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		3,235,123.0	3,235,123.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		5,730,325.8	5,853,611.8

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,104,139.1	2,701,806.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	61,600.4	150,778.6
110	Орлогын албан татвар	32,982.3	36,747.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	32,982.3	36,747.4
113	Хөрөнгийн албан татвар	1,356.0	86,572.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,262.1	27,459.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	469,824.7	243,435.4
120	Нийтлэг татварын бус орлого	469,824.7	243,435.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,572,714.0	2,307,592.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,747,626.5	2,440,502.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,747,626.5	2,440,502.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,060,824.1	2,298,228.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,215,808.2	1,285,685.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,520.5	168,923.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,761.5	202,277.0
2104	Хангамж, бараа материалын зардал	63,437.4	70,568.2
2105	Нормативт зардал	100,281.2	147,027.0

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,087.9	25,698.4
2107	Томилолт, зочны зардал	4,228.9	2,502.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,632.2	10,155.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	314,066.3	385,391.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	686,802.4	142,274.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	356,512.6	261,303.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	63,615.4	137,540.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	292,897.2	123,762.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,729,093.1	2,913,099.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	61,600.4	150,778.6
110	Орлогын албан татвар	32,982.3	36,747.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	32,982.3	36,747.4
113	Хөрөнгийн албан татвар	1,356.0	86,572.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,262.1	27,459.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,214.8	4,372.2
1181	Газрын төлбөр	2,947.2	1,675.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,100.1	21,411.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,978.2	97,744.8
120	Нийтлэг татварын бус орлого	71,978.2	97,744.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,595,514.5	2,664,576.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,527,907.9	2,160,473.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,527,907.9	2,160,473.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,818,007.5	2,015,899.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,216,807.5	1,283,775.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,650.9	167,822.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,204.5	202,277.0
2104	Хангамж, бараа материалын зардал	64,830.8	64,302.8
2105	Нормативт зардал	101,696.2	155,807.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,925.9	24,915.1
2107	Томилолт, зочны зардал	4,228.9	2,502.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,229.8	11,858.9

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,433.0	102,638.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	709,900.4	144,574.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	201,185.2	752,626.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	109,038.6	148,269.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,038.6	148,269.8
2200	Дотоод эх үүсвэрээр	109,038.6	148,269.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-109,038.6	-148,269.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	33,146.6	604,356.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	61,767.0	94,913.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	94,913.6	329,394.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,424,398.3	0.0	5,424,398.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,424,398.3	0.0	5,424,398.3
Тайлант үеийн үр дүн	292,897.2	0.0	292,897.2
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,717,295.5	0.0	5,717,295.5
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,717,295.5	0.0	5,717,295.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,717,295.5	0.0	5,717,295.5
Тайлант үеийн үр дүн	123,762.9	0.0	123,762.9
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,841,058.4	0.0	5,841,058.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,354,717.20	2,072,701.90	282,015.30	88.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,090,012.50	1,946,351.40	143,661.10	93.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,007,650.50	1,864,897.10	142,753.40	92.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,299,923.60	1,268,225.20	31,698.40	97.56
210101	Үндсэн цалин	924,712.00	908,898.80	15,813.20	98.29
210102	Нэмэгдэл	276,053.20	265,265.30	10,787.90	96.09
210104	Урамшуулал	78,113.40	78,376.10	-262.70	100.34
210105	Гэрээт ажлын хөлс	21,045.00	15,684.90	5,360.10	74.53

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,535.60	165,801.30	6,734.30	96.10
210201	Тэтгэврийн даатгал	120,499.00	115,844.40	4,654.60	96.14
210202	Тэтгэмжийн даатгал	13,008.80	12,715.70	293.10	97.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,407.40	10,066.30	341.10	96.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,601.80	2,493.10	108.70	95.82
210205	Эрүүл мэндийн даатгал	26,018.60	24,681.90	1,336.70	94.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	281,390.40	202,277.00	79,113.40	71.88
210301	Гэрэл, цахилгаан	26,358.30	21,178.90	5,179.40	80.35
210302	Түлш, халаалт	251,114.30	177,200.30	73,914.00	70.57
210303	Цэвэр, бохир ус	3,917.80	3,897.80	20.00	99.49
2104	Хангамж, бараа материалын зардал	62,263.60	60,256.40	2,007.20	96.78
210401	Бичиг хэрэг	7,258.70	7,154.00	104.70	98.56
210402	Тээвэр, шатахуун	31,706.30	31,575.60	130.70	99.59
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,773.90	8,673.90	100.00	98.86
210404	Ном, хэвлэл	1,077.60	1,037.90	39.70	96.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,207.60	7,803.90	1,403.70	84.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,239.50	4,011.00	228.50	94.61
2105	Нормативт зардал	91,070.70	80,919.70	10,151.00	88.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,165.50	34,989.40	176.10	99.50
210502	Хоол, хүнс	47,731.60	37,776.20	9,955.40	79.14
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,173.60	8,154.20	19.40	99.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,958.00	44,474.50	483.50	98.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,250.00	21,766.60	483.40	97.83
210604	Урсгал засвар	22,708.00	22,707.90	0.10	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,963.20	2,322.30	640.90	78.37
210702	Дотоод албан томилолт	2,963.20	2,322.30	640.90	78.37
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,778.10	11,041.50	2,736.60	80.14
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,337.10	9,054.50	1,282.60	87.59
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,952.00	1,512.00	1,440.00	51.22
210803	Даатгалын үйлчилгээ	240.00	240.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165.00	165.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70.00	70.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	14.00	0	14.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,767.30	29,579.10	9,188.20	76.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,650.00	24,461.80	9,188.20	72.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,117.30	5,117.30	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,362.00	81,454.40	907.60	98.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	82,362.00	81,454.40	907.60	98.90
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,293.30	20,394.30	899.00	95.78
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,868.70	58,868.70	0.00	100.00

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,200.00	29,191.40	-26,991.40	1,326.88
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	140,704.70	126,350.60	14,354.10	89.80
220001	Барилга байгууламж	115,704.70	106,350.60	9,354.10	91.92
222001	Тоног төхөөрөмж	20,000.00	20,000.00	0.00	100.00
223001	Бусад хөрөнгө	5,000.00	0	5,000.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	124,000.00	0	124,000.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	124,000.00	0	124,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,354,717.20	2,181,124.50	173,592.70	92.63
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,267,558.40	1,267,558.40	0.00	100.00
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,267,558.40	1,267,558.40	0.00	100.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	925,677.80	827,107.00	98,570.80	89.35
320001	Орон нутгийн төсвөөс	818,521.70	719,950.90	98,570.80	87.96
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	107,156.10	107,156.10	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,932.40	19,464.70	2,467.70	88.75
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	21,932.40	19,464.70	2,467.70	88.75
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	139,548.60	66,994.30	72,554.30	48.01
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	104,975.30	66,994.30	37,981.00	63.82
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	34,573.30	0	34,573.30	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	668	664	4.00	99.40
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	8	8	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	106	104	2.00	98.11
620001	Удирдах ажилтан	14	12	2.00	85.71
620002	Гүйцэтгэх ажилтан	57	59	-2.00	103.51
620003	Үйлчлэх ажилтан	32	29	3.00	90.63
620004	Гэрээт ажилтан	3	4	-1.00	133.33
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	448	448	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	106	104	2.00	98.11
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10	13	-3.00	130.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	45	45	0.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	6	6	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	16	2.00	88.89
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22	19	3.00	86.36
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,669.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,669.50

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	172,921.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,549.90
210102	Нэмэгдэл	15,384.90
210104	Урамшуулал	165.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,020.80
210201	Тэтгэврийн даатгал	1,405.50
210202	Тэтгэмжийн даатгал	151.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	125.10
210204	Ажилгүйдлийн даатгал	30.70
210205	Эрүүл мэндийн даатгал	307.70
2104	Хангамж, бараа материалын зардал	4,046.40
210401	Бичиг хэрэг	176.00
210402	Тээвэр, шатахуун	1,395.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	118.80
210404	Ном, хэвлэл	1,678.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	675.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2.50
2105	Нормативт зардал	74,887.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	74,887.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,359.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,359.80
2107	Томилолт, зочны зардал	180.00
210702	Дотоод албан томилолт	180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	817.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	817.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,059.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,059.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,747.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,147.90
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	16,147.90
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	210,669.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	210,669.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	13,559.20
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,140.40
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,954.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	102,617.30
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	27,397.60

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Сант сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн нөөц хөрөнгийг зарцуулж байх, төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг бүртгэж байх, эд хариуцагч, албан хаагч тус бүрээр шаардах хуудас бичүүлж байх, жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөх, тээврийн хэрэгслийн ашиглалтын дэвтрийг хөтлөх, гэрээт ажилчдын цалингаас НДШ суутгаж байх, ур чадварын нэмэгдлийг ажлын үр дүнг улирлаар дүгнэж, сар бүр олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сант сумын ТТЗ нь тайлант оны үйл ажиллагааны зорилгыг “Хамтын сэтгэл хичээл зүтгэлээр сум, баг, айл өрхөөрөө хөгжин дэвшилцгээе” гэж тодорхойлсон бөгөөд зорилгынхоо хүрээнд дор дурдсан зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- 1 Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- 2 Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- 3 Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- 4 Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- 5 УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- 6 Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,

- 7 Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- 8 Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- 9 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,
- 10 Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- 11 Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- 12 Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Сант сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дээд шатны төсвийн захирагчаас дотоод аудит хийгдээгүй байна.

ТТЗ-ийн удирдлагын зүгээс тайлант онд хэрэгжүүлсэн дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзэж байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн

эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,197,398.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон **47,960.9** мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 35,970.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 94,913.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 329,393.9 мянган төгрөг болж, 234,480.3 мянган төгрөгөөр өссөн байна. Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	94,913.60	329,393.90	234,480.30
Замд яваа мөнгөн хөрөнгө	-	-	-
Хадгаламж	-	-	-
Дүн	94,913.60	329,393.90	234,480.30

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын дансанд 224,917.8 мянган төгрөг, ОНХС-д 14,354.1 мянган төгрөг, СХС-д 90,121.9 мянган төгрөг нийт 329,393.9 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 197,631.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 135,882.4 мянган төгрөг болж, 62,507.6 мянган төгрөгөөр буурсан байна. Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	31.80	-	(31.80)
Татаас, санхүүжилтийн авлага	11,626.60	12,385.40	
Зээлийн хүүгийн авлага	17,596.90	12,810.00	(4,786.90)
Байгууллагаас авах авлага	937.10	1,270.70	333.60
Хувь хүмүүсээс авах авлага	6,085.70	6,980.60	894.90
Хувь хүмүүст олгосон зээл	161,353.10	102,435.70	(58,917.40)
Дүн	197,631.20	135,882.40	(62,507.60)

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татаас, санхүүжилтийн авлага оны эцэст 12,385.4 мянган төгрөг байгаа нь ЭМТ нь ЭМД-ын сангийн ковидын гэрийн эмчилгээ болон вакцины санхүүжилтийг дутуу олгосноос үүссэн авлагатай холбоотой байна.

Байгууллагаас авах авлага оны эцэст 1,270.7 мянган төгрөг байгаа нь ЗДТГ төрөөс хариуцах 12 сарын цэвэр усны төлбөрийг авлагаар бүртгэснээс шалтгаалсан байна.

Хувь хүмүүсээс авах авлага 894.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ЭМТ эмийн сангаас хувь хүмүүст зээлээр борлуулсан эмийн тооцоотой холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай СХС болон орон нутгийн ерөнхий орлогын дансанд бүртгэлтэй 38,418.2 мянган төгрөгийн авлага байна. Үүнд:

- Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 17 иргэнээс авах 2011-2013 онд олгосон өвс, тэжээл болон итгэлийн зээлийн төлөгдөөгүй 6,085.6 мянган төгрөгийн авлага,
- СХС-аас өгсөн зээлийн эргэн төлөгдөх хугацаа хэтэрсэн, 3-аас дээш жилийн насжилттай 32,332.6 мянган төгрөгийн авлага байна.

СХС-аас олгосон зээлийг Монгол банкны мэдээллийн санд оруулдаг болсноор 2021 онд хугацаа хэтэрсэн 27 зээлдэгчийн 29,320.6 мянган төгрөгийн зээл бүрэн төлөгдөж хаагдсан бөгөөд тайлант онд шүүхэд 4, ШШГГ-т 2 зээлдэгчийн материалыг хүргүүлсэн, 2 зээлдэгчтэй эвлэрлийн гэрээ байгуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

ЭМТ нь эмийн сангийн зээлийн борлуулалтын эмийн орлогын тооллого, тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 894.9 мянган төгрөгийн авлага үүсгэж, санхүүгийн тайланд дутуу тусгасан.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 130,843.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 179,818.8 мянган төгрөг болж, 58,535.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	12,297.20	22,550.80	10,253.60
Эм боох материал	12,464.90	29,461.30	16,996.40
Бэлэн бүтээгдэхүүн			-
Бичиг хэргийн материал	836.00	899.00	63.00
Аж ахуйн материал	36,999.10	15,781.60	(21,217.50)
Сэлбэг хэрэгсэл			-
Түлш, шатах тослох материал			-
Барилгын засварын материал	8,046.80	3,643.30	-
Хүнсний материал	5,156.90	11,103.30	11,103.30
Бусад хангамжийн материал	55,042.70	96,379.50	41,336.80
Дүн	130,843.60	179,818.80	58,535.60

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 58,535.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 354,373.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, хандив, тусламжаар 29,608.1 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 13,980.4 мянган төгрөгийн бараа материал тус тус хүлээн авсан, данснаас дансанд 22,958.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авсан зэргээр нийт 420,921.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 275,390.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 92,364.8 мянган төгрөгийн бараа материалыг данснаас дансанд шилжүүлэн, 4,190.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данснаас хассанаас шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна Үүнд:

- ИТХ нь 6,590.0 мянган төгрөгийн,
- ЗДТГ нь 32,625.8 мянган төгрөгийн,
- Соёлын төв нь 4,300.0 мянган төгрөгийн,
- ЭМТ нь 28,923.9 мянган төгрөгийн,
- Цэцэрлэг 278.1 мянган төгрөгийн
- Сургууль 212,044.8 мянган төгрөгийн гэх мэт.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл /анхны өртгөөр/ 6,380,460.6 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 6,348,438.7 мянган төгрөг болж 32,021.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	4,941,735.20	4,941,735.20	-
Хуримтлагдсан элэгдэл	(437,819.90)	(615,656.10)	(177,836.20)
Авто-тээврийн хэрэгсэл	222,555.40	212,555.40	(10,000.00)
Хуримтлагдсан элэгдэл	(117,729.90)	(108,244.40)	9,485.50
Машин тоног төхөөрөмж (компьютер)	488,713.60	433,867.50	(54,846.10)
Хуримтлагдсан элэгдэл	(321,807.30)	(237,842.70)	83,964.60
Тавилга, аж ахуйн эд хогшил	240,120.60	171,974.60	(68,146.00)
Хуримтлагдсан элэгдэл	(146,962.90)	(108,126.40)	38,836.50
Бусад үндсэн хөрөнгө	256,604.20	356,427.20	99,823.00

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хуримтлагдсан элэгдэл	(46,750.00)	(66,696.80)	(19,946.80)
Дуусаагүй барилга, байгууламж	46,116.60	46,116.60	-
Ном	31,507.10	33,054.30	1,547.20
Программ хангамж	8,629.00	8,229.00	(400.00)
Хуримтлагдсан элэгдэл	(2,453.20)	(3,355.60)	(902.40)
Бусад биет бус хөрөнгө	144,478.80	144,478.80	-
Дүн	5,306,937.30	5,208,516.60	(98,420.70)

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 41,919.2 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив, тусламжаар 7,910.7 мянган төгрөгийн, данснаас дансанд шилжүүлэн авсан 69,406.1 мянган төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 86,861.5 мянган төгрөгийн хөрөнгө тус тус нэмэгдэж, 238,119.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

3.5.5 Өр төлбөр

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 13,030.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 12,553.4 мянган төгрөг болж, 476.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,013.90	2,013.90
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,403.70	10,539.50	9,135.80
Байгууллагад төлөх өглөг	11,626.60	-	(11,626.60)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,030.30	12,553.40	(476.90)

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа үйлчилгээний зардлын өглөг оны эцэст 10,539.5 мянган төгрөг байгаа нь Ковидын санхүүжилт дутуу орж ирснээс шалтгаалж эмийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Ажилчидтай холбоотой өглөг оны эцэст 2,013.9 мянган төгрөг байгаа нь ЭМТ Ковидын илүү цагтай холбоотой 1,845.9 мянган төгрөгийн цалингийн өглөг, ИТХ-ын нарийн бичгийн даргын ЭБАТ-ын нэмэгдэл цалингийн 168.0 мянган төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5,717,295.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,841,058.4 мянган төгрөг болж, 123,762.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,386,441.90	2,386,441.90	-
Өмнөх үеийн үр дүн	(197,166.50)	95,730.70	292,897.20
Тайлант үеийн үр дүн	292,897.20	123,762.90	(169,134.30)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,235,122.90	3,235,122.90	-
Дүн	5,717,295.50	5,841,058.40	123,762.90

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,841,058.4 мянган төгрөг болж, 123,762.9 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

3.5.7 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 17,352.8 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ТТЗ :

- Төрийн албан хаагчдын орон сууцыг түрээслүүлсний орлогын 20 хувь болох нийт 1,165.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй,
- Аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажил”-ын 1,315.1 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардлыг ОНХС-ийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

ИТХ :

- ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Туяасайханд 200.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг давхардуулан олгосон байна.

ЗДТГ:

- Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийгдсэн “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажил”-ын гүйцэтгэгч Хөтөл цэнэг ХХК-д 339.1 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон,
- Батлагдсан орон тоог 2-оор хэтрүүлэн 10,544.5 мянган төгрөгийн цалин олгосон байна.

ЭМТ:

- Эмийн сангийн зээлийн борлуулалтын тооллого, тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 3,519.3 мянган төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн,
- Эмийн сангийн 269.3 мянган төгрөгийн орлогыг төрийн санд тушаалгүйгээр яаралтай тусламжийн эмийн зардалд зарцуулсан байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сант сумын ИТХ-ын “2021 оны орон нутгийн төсөвт тодотгол оруулах тухай” 2021 оны 20 дугаар тогтоолоор тайлант онд 56,330.0 мянган төгрөгийн татварын орлого, 15,000.0 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 181,529.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 154.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №.7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Сумын төсвийн татварын орлого	56,330.00	150,778.60	94,448.60	267.67
Үйл ажиллагааны орлого	10,000.00	12,429.20	2,429.20	124.29
Хөрөнгийн орлого	100.00	17,534.20	17,434.20	17,534.20
Хөрөнгө борлуулсны орлого	2,200.00	6,784.00	4,584.00	308.36
Бууны албан татвар	1,480.00	960.00	(520.00)	64.86
Малд ногдуулах албан татвар		85,612.00	85,612.00	
Улсын тэмдэгтийн хураамж	2,500.00	1,953.30	(546.70)	78.13
Түгээмэл тархацтай АМ ашигласны төлбөр	1,000.00	72.50	(927.50)	7.25
Хог хаягдал үйлчилгээ	8,000.00	2,346.50	(5,653.50)	29.33
Газрын төлбөр	7,504.00	1,675.40	(5,828.60)	22.33
Газрын дуудлага худалдаа	5,000.00		(5,000.00)	-
Ойн нөөц ашигласны төлбөр	17,000.00	17,802.00	802.00	104.72
Агнуурын нөөц ашигласны төлбөр	1,246.00	1,162.00	(84.00)	93.26
Байгалийн ургамал ашигласны төлбөр	300.00	2,447.50	2,147.50	815.83
Сумын төсвийн татварын бус орлого	15,000.00	30,750.40	15,750.40	205.00
Бусад орлого	2,500.00	1,370.00	(1,130.00)	54.80
Торгуулийн орлого	10,000.00	26,573.90	16,573.90	265.74
Түрээсийн орлого	2,500.00	2,806.50	306.50	112.26
Дүн	71,330.00	181,529.00	110,199.00	254.49

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд хөрөнгийн орлого 17,434.2 мянган төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 4,584.0 мянган төгрөгөөр, торгуулийн орлого 16,573.9 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төлөвлөгдөөгүй орлого болох малд ногдуулах албан татварын орлого 85,612.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Хөрөнгийн орлого 17,434.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь иргэдийн банкин дахь хадгаламжийн хүүгийн орлогыг төлөвлөөгүй байснаас шалтгаалсан,
- Хөрөнгө борлуулсны орлого 4,584.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь тайлант онд 20 иргэн газар эзэмших эрхээ шилжүүлсэнтэй холбоотой,
- Торгуулийн орлого 16,573.9 мянган төгрөгөөр давсан нь Сайхан сумын цагдаагийн тасагтай хамтарч ажилласантай холбоотой байна.

Тасарсан орлого:

- Хог хаягдлын үйлчилгээний орлого 5,653.5 мянган төгрөгөөр тасарсан нь төрөөс олгох санхүүжилт дутуу төвлөрсөнтэй холбоотой.
- Газрын төлбөрийн орлого 5,828.6 мянган төгрөгөөр тасарсан нь газар тариалангийн компаниудын үйл ажиллагаа тасалдсантай холбоотой,
- Газрын дуудлага худалдааны орлого 5,000.0 мянган төгрөгөөр тасарсан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 2,227,849.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 13 дугаар тогтоолоор нийт эх үүсвэр болон зардлыг 2,227,849.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 20 дугаар тогтоолоор дараах өөрчлөлтүүд орж сумын төсөв **2,320,258.5** мянган төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 7,000.0 мянган төгрөгөөр, торгуулийн орлогыг 5,000.0 төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, Соёлын төвийн

халаалтын зардлыг 1,100.0 мянган төгрөгөөр бууруулан, Засаг даргын нөөц хөрөнгийг 12,872.0 мянган төгрөгөөр нэмж баталсан,

- Баяр наадмын зардлын 5,000.0 мянган төгрөгийг хасаж, ЗДТГ-ын цалингийн зардлыг 3,528.0 мянган төгрөгөөр, гудамжны гэрэлтүүлгийн зардлыг 1,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон,
- Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих ЕБС-ийн санхүүжилтийг 83,830.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цэцэрлэгийн санхүүжилтийг 8,421.3 мянган төгрөгөөр бууруулсан,
- Аймгаас суманд өгөх санхүүгийн дэмжлэг 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, ЭМТ-ийн тогтмол зардлыг нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын ИТХ-ын тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан **2,320,258.5** мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч сургууль, цэцэрлэгийн батлагдсан төсөвт өөрчлөлт орсноор **2,354,717.2** мянган төгрөгөөр эцэслэн батлагдаж, 2,088,512.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 140,704.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 125,500.0 мянган төгрөгийг зарцуулахаар тогтоожээ.

Нийт зардлын 1,267,558.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 21,932.4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 701,478.1 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 71,330.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 45,713.6 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 125,500 мянган төгрөгийг СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс, 107,156.1 мянган төгрөгийг ОНХС-аас, 13,548.6 мянган төгрөгийг ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,267,558.4 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 19,464.7 мянган төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 701,478.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 18,472.9 мянган төгрөг, ОНХС-аас 107,156.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 500.0 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 66,494.3 мянган төгрөг зэрэг нийт **2,181,124.5** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,072,701.9** мянган төгрөг буюу 88 хувьтай тайлагнагдсан нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 38,432.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 79,113.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 2,007.2 мянган төгрөгөөр, нормативт зардал 10,159.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 483.4 мянган төгрөгөөр, албан томилолтын зардал 641.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 2,736.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 9,188.2 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох

тэтгэмж, урамшуулал 899.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 14,354.0 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээл 124,000,0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд 20,000.0 мянган төгрөг олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр санхүүжилт бүрэн олгогдсон байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 9 төсөл, арга хэмжээнд 120,704.7 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 106,350.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, оны эхний зарцуулагдаагүй үлдэгдлийн хамт 14,354.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдын 61,954.9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5,140.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 102,617.3 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 13,559.2 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 27,397.6 мянган төгрөг зэрэг нийт 210,669.5 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 15,549.9 мянган төгрөг, НДШ-д 2,020.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 4,046.4 мянган төгрөг, нормативт зардалд 74,887.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2,359.8 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 180.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 817.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 73,059.7 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 37,747.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т *“Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг **улсын төсөвт үйлдвэрийн газар** гэнэ”*, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан *“Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”*-ын 3.1-д *“Төрийн албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацаанд дараах хугацааг оруулан тооцно”*, 3.1.4: *“Улсын төсөвт үйлдвэрийн газрын гүйцэтгэх захирал, захиргааны ажилтан, бусад ажилтнаар 1996 оны 8 дугаар сарын 1-ээс 2008 оны 5 дугаар сарын 6-ны өдөр хүртэл ажилласан хугацаа”* гэж зохицуулсан байдаг.

Гэтэл өндөр насны тэтгэвэр тогтоолгосон санхүүгийн албаны даргаар ажиллаж байсан Д.Бямбасүрэнгийн Цагаан толгой САА-д ажиллаж байсан 7 жилийн хугацааг төрийн албанд ажилласан хугацаанд оруулан тооцож, буцалтгүй тусламж олгохоор аймгийн СТСХ-ээс хянаж, ирүүлсний дагуу нийт 5,957.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Дээр дурдсан Цагаан толгой САА нь улсын төсөвт үйлдвэрийн газар мөн эсэх талаарх эрсдэл үүсгэж байгаа учир төрийн албанд ажилласан хугацааг үнэн зөв тодорхойлж, тэтгэмж олгох нь зүйтэй гэж үзэж байна.

2. Иргэн, хуулийн этгээдээс ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулан ЗДТГ-т 13,559.2 мянган төгрөгийн хандив тусламжийн орлого төвлөрсөн байна. Хандивын орлогыг сумын Онцгой комиссын шийдвэрээр зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

1. ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн усны орлогоос худаг ажиллуулж байгаа 1 ажилтантай хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага дүнгээр сарын 250.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, 500.0 мянган төгрөгийн цалин олгосон байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. ТТЗ нь нийт 79 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
2. ЗДТГ нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 17 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
3. ИТХ нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.
4. Соёлын төв нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 6 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

5. ЭМТ нь нийт 119 мэдээллийг шилэн дансны цахим санд оруулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн бол 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт:

- ИТХ-ын тайлант оны үйл ажиллагаанд 85,757.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 83,756.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.4 хувиар хэмнэсэн,
- ЗДТГ-ын тайлант оны үйл ажиллагаанд 385,158.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 369,875.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4 хувиар хэмнэсэн,
- ЭМТ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 350,622.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 348,154.7 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.7 хувиар хэмнэсэн,
- Соёлын төвийн тайлант оны үйл ажиллагаанд 93,776.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 89,377.3 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.7 хувиар хэмнэсэн,
- Цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 299,074.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 272,024.2 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсөвт зардлыг 9.1 хувиар хэмнэсэн,

3.10 Өмнөх аудитаар өгсөн акт, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 356.8 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 5,542.7 мянган төгрөгийн 8 албан шаардлага, 9,335.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлснийг 87.5 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	356.80	1	356.80	-	-	100
Албан шаардлага	8	5,542.70	7	5,542.70	1	-	87.5
Зөвлөмж	4	9,335.70	3	9,335.70	1	-	75
Нийт	13	15,235.20	11	15,235.20	2	-	84.6

Эх сурвалж: Сант сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, холбогдох баримтууд

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан бөгөөд харин төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ОНХС-ийн зарцуулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.


4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 6, орон нутгийн төсөл сангийн 2, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс, ЕБС, цэцэрлэгийн санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 4 байгууллага, 2 төсөл сангийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Сант сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 388,277.5 мянган төгрөгийн 30 алдаа, зөрчил илрүүлснээс 43,253.2 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 5,223.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,023.8 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага өгч, 326,776.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 14 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 2 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 162,078.7 мянган төгрөгийн 20 алдаа, зөрчил илрүүлснээс 41,197.2 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 5,223.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 13,023.8 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага өгч, 102,633.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүллээ.



4.1 Залруулга:

Нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаанаас үүссэн 24,810.4 мянган төгрөгийн дараах ажил гүйлгээг аудитын явцад илрүүлж, санхүүгийн тайланд залруулга хийлгэв. Үүнд:

ЗДТГ:

- Төрөөс хариуцах цэвэр усны төлбөрийн 12 дугаар сарын санхүүжилтийн авлага 1,270.7 мянган төгрөгийг дутуу тайлагнасан,
- Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн үндсэн үйл ажиллагааны орлого 13,977.8 мянган төгрөгийг данс буруу ангилан бүртгэсэн,
- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 8,650.5 мянган төгрөгийн БМ-ыг зарлагадахдаа үнэ төлбөргүй гарсан БМ-ын дансанд бүртгээгүй.

ЭМТ:

- Тайлант онд эмийн сангаас хувь хүмүүст зээлээр борлуулалт хийж, төлбөрийг барагдуулаагүйгээс үүссэн 894,9 мянган төгрөгийн авлагыг дутуу бүртгэсэн.

СХС:

- СХС-ийн тайлант оны хүүгийн орлогыг 16,383.3 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

1. ЭМТ нь эмийн сангийн зээлийн борлуулалтын тооллого, тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс **3,519.3** мянган төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн эмийн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. ТТЗ нь төрийн албан хаагчдын орон сууцыг түрээслүүлсний орлогын 20 хувь болох нийт **1,165.5** мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2014 оны 25 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын 2.14 дэх *“Түрээслэгчийн түрээслэгчээс авч буй түрээсийн төлбөрийн нэгдсэн судалгаа гаргаж, түрээсийн төлбөрийн нийт дүнгийн 20 хувийг орон нутгийн хөрөнгө худалдан борлуулсны орлогын дансанд байршуулна”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. ЗДТГ нь аймгийн замын сангийн хөрөнгөөр хийгдсэн *“Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажил”*-ын гүйцэтгэгч Хөтөл цэнэг ХХК-д **339.1** мянган

төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 10.7-д “... дараах материалыг үндэслэн санхүүжүүлнэ. Үүнд: 10.7.2: “захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь...” гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний 2-д “Гэрээний нийт дүн 29,154,070.0 төгрөг Үүнээс: захиалагчийн албаны зардал 555,086.0 зураг төсөл зохиогчийн хяналтын зардал 277,543.0, магадалшгүй ажлын зардал 555,086.0, инженер хайгуул, зураг төслийн зардал 277.543.0” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэгч байгууллагад илүү шилжүүлсэн санхүүжилтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4. ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Туяасайханд томилолтын зардал 200.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 АЛБАН ШААРДЛАГА

1. ЗДТГ нь аймгийн ЗДТГ-ын СТС-ийн хэлтсийн хянасан орон тоог 2-оор хэтрүүлэн 10,544.5 мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ; 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хянагдсан орон тооны хязгаарт багтаан орон тоог шинэчлэн тогтоох албан шаардлага хүргүүлэх.

2 Аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн ажил”-ын 1,315.1 мянган төгрөгийн захиалагчийн хяналтын зардал, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардлыг ОНХС-ийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; “ Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.28-д “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, ... санхүүжүүлэхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн

бөгөөд санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах албан шаардлага хүргүүлэх.

3. ЭМТ нь эмийн сангийн зээлийн борлуулалтын эмийн орлогын тооллого, тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 894.9 мянган төгрөгийн авлага үүсгэж, санхүүгийн тайланд дутуу тусгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *"Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"*, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх *"Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ; 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог хянан баталгаажуулах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

4. ЭМТ нь эмийн сангийн 269.3 мянган төгрөгийн орлогыг төрийн санд тушаалгүйгээр яаралтай тусламжийн эмийн зардалд зориулалт бусаар зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д *"батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"*, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан *"Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"*-ын 2.6-д *"Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-аас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана."* гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *"Нийцсэн бөгөөд зохистой байх"* батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, өөрийн орлогыг төрийн сан дахь бүртгэлийн дансанд тухай бүр тушааж байх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Засаг даргын нөөц хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс 13,298.1 мянган төгрөгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүй зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан *"Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"*-ын 4.1-д *"Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна."*, 5.2-д *"Тухайн шатны Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж шийдвэрийн төсөл болон холбогдох тооцоог хянаж Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр Засаг даргын*

захирамж гаргуулна.” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн нөөц хөрөнгийг зарцуулж байх.

2. Анхан шатны баримттай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт: Тайлант онд ИТХ нь 6,590.0 мянган төгрөгийн, ЗДТГ нь 32,625.8 мянган төгрөгийн, Соёлын төв нь 4,300.0 мянган төгрөгийн, ЭМТ нь 28,823.9 мянган төгрөгийн зэрэг нийт **72,339.7** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

2.2.1 Илрүүлэлт: ЭМТ нь 6,000.0 мянган төгрөгийн хангамжийн материалыг зарцуулахдаа шаардах хуудсыг албан хаагч тус бүрээр бус нярав, үйлчлэгч гэх мэт 1 хүний нэр дээр бөөн дүнгээр бичиж, тайлагнасан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 3.6 “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ.” гэж заасныг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2.2 Өгсөн зөвлөмж: Бараа материалыг зарцуулахдаа тухай бүр эд хариуцагч, албан хаагч тус бүрээр шаардах хуудас үйлдүүлж, холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авсны дараа олгож байх.

2.3.1 Илрүүлэлт: ЭМТ нь жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан км болон зарцуулсан хугацаа, шатахууны зарцуулалтын норм, спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй, стандарт маягтаар хөтлөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэж заасныг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “*Маягт заавар батлах тухай*” тушаалын хавсралт “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*”-ыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.3.2 Өгсөн зөвлөмж: Цаашид жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан км болон зарцуулсан хугацаа, шатахуун зарцуулалтын норм, спидометрийн заалтыг бүрэн бүртгэж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

2.4.1 Илрүүлэлт: ЗДТГ нь 2,671.0 мянган төгрөгийн автомашины сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгэж, баталгаажуулаагүй, тайлант жилд явсан гүйлт, км, зарцуулсан шатахууны тооцоог бүрэн бүртгээгүй байна. Энэ нь Стандартчилал, Хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2011 оны 51 дүгээр тогтоолоор баталсан заавал мөрдөх “*Авто тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо, тодорхойлолт*” MNS 4601-2011 стандартыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.4.2 Өгсөн зөвлөмж: Цаашид авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг хөтөлж, урсгал болон их засвар, нийт км, шатахуун зарцуулалтуудын тооцоог бүрэн бүртгэн, авто механикийн хяналтыг сайжруулах

4. Цалин, хөлстэй холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн усны орлогоос цалинжуулсан 2 гэрээт ажилтны 8,325.0 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй нь НДШ-ийн өр төлбөр үүсгэх эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “*Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 17.1.1: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;*” гэсэн заалтыг зөрчсөн ба “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид гэрээт ажилчдын цалинг нийгмийн даатгалын тайланд бүрэн тайлагнаж байх, дээрх зөрчлийг 2022 оны 2 дугаар улиралд багтаан залруулах.

4.2.1 Илрүүлэлт: ЗДТГ нь төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирал бүр дүгнэлгүйгээр оны эхэнд тушаал гаргаж, бүтэн жилийн турш олгож ирсэн байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох

нийтлэг журмын 3-д "Төрийн үйлчилгээний байгууллагын... албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу ... тооцож, сар бүр олгоно" гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Өгсөн зөвлөмж: Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу улирлаар дүгнэж, сар бүр ур чадварын нэмэгдлийг олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс				Хариуцлага тооцох		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Залруулга	Акт		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
							Тоо	Дүн						
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1			Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэргүй зарцуулсан.	1	13,298.1								1	13,298.1
2			Төсөвт байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй.	1	72,339.7								1	72,339.7
3			Түрээсийн орлогын 20 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй.	1	1,165.5				1	1165.5				
4	ТТЗ	СЭА-2022/10-НА-СТА-ТТЗ	Аймгийн замын сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэгч Хөтөл цэнэг ХХК-д санхүүжилтийг илүү тооцож олгосон.	1	339.1				1	339.1				
5			Хянагдсан орон тоог 2-оор хэтрүүлсэн байна.	1	10,544.5						1	10,544.5		
6			Автомашин сэлбэг болон засварын зардлыг авто тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтэрт бүртгээгүй.	1	2,671.0								1	2,671.0
8			ЗДТГ нь гэрээт ажилтны цалингаас НДШ суутгаагүй, нийгмийн даатгалын тайланд тайлагнаагүй байна.	1	8,325.0								1	8,325.0

Сант сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

18			Тайлант онд эмийн сангийн зээлийн борлуулалтын авлагыг дутуу бүртгэсэн.	1	894.9	1	894.9								
19			ИТХ нь томилолтын зардлыг давхардуулан олгосон.	1	200.0			1	200						
20	ТТЗ	СЭА-2022/10-НА-СТА-ТТЗ	ОНХС-ийн санхүүжилтээс аймгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээний зардлыг санхүүжүүлсэн.	1	1,315.1					1	1,315.1				
21			СХС-ийн тайлант оны хүүгийн орлогыг илүү бүртгэсэн.	1	16,383.3	1	16,383.3								
				20	162,078.7	5	41,197.2	4	5,223.9	4	13,023.8	0	0	7	102,633.8

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал

1	ТТЗ	СЭА-2022/02-НА-СТА-ТТЗ	Төсөвт байгууллагууд нь шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон буюу огт мэдээлээгүй	1	-					1					
2			ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй	1	-					1					
				2						2					
НИЙТ ДҮН				22	162,078.7	5	41,197.2	4	5,223.9	6	13,023.8	-	-	8	102,633.8